

Аймгийн эдийн засаг, нийгмийн байдал (2014 оны эхний 3 сарын байдлаар)

I. Төсвийн орлого



Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэдээгээр 2014 оны эхний 3 сарын байдлаар орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт 127.6 хувьтай буюу 885.8 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Үүний гадна улсын төвлөрсөн төсөвт оруулбал зохих орлогын төлөвлөгөө 165.1 хувиар давж биелэн 510.3 сая төгрөгийн орлогыг улсын төвлөрсөн төсөвт оруулаад байна. Улсын болон орон нутгийн төсөвт нийт дүнгээр 1396.1 сая төгрөгийн орлого оруулж, аймгийн дүнгээр орлогын төлөвлөгөөний биелэлт 139.1 хувьтай байна.

Тусламжийн орлогыг оруулан тооцсоноор аймгийн хэмжээний нийт орлого ба тусламж 9289.1 сая төгрөг болж, төлөвлөгөөний биелэлт 94.3 хувьтай байна. Орон нутгийн төсөвт улсын төсвөөс авсан санхүүгийн дэмжлэг 2468.1 сая төгрөг, Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн орлогын шилжүүлгээс 628.3, тусгай зориулалтын шилжүүлгээс 5307,0, нийт 8403,4 сая төгрөгийн тусламжийн орлого орсон байна.

Орон нутгийн төсвийн орлогынхоо төлөвлөгөөг Өлзийт сум 30428.9 мянган төгрөгөөр тасалж, бусад сумд төлөвлөгөөгөө 7.4-540.7 хувиар давуулан биелүүлжээ.

Төсвийн зарлага



Орон нутгийн төсвийн зарлага оны эхний 3 сарын байдлаар 7253.4 сая төгрөг болж өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал 17.4 хувиар өсчээ. Зарлагын төрлөөр авч үзвэл цалин хөлсний зардал өмнөх оноос 2.4 хувиар өсч 3761,7 сая төгрөг, нийгмийн халамжийн үйлчилгээ 667,2 сая болж өмнөх оноос 27,9 хувиар буурчээ.

II. Банк



Банкны зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 50.0 хувиар өсч 59977.6 сая төгрөг болов. Үүнээс хугацаа хэтэрсэн зээл 76.3 сая төгрөг болж өмнөх оны мөн үеэс 103.2 хувиар өсчээ. Чанаргүй зээл 71,6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Нийт зээлийн үлдэгдлийн 0,25 хувийг хугацаа хэтэрсэн ба чанаргүй зээл эзэлж байна. Иргэдийн

хувийн хадгаламж өмнөх оноос 18,7 хувиар өсч 21839,7 сая төгрөг болов.

III. Бүртгэлтэй ажилгүй иргэн



2014 оны эхний 3 сарын байдлаар аймгийн хөдөлмөрийн хэлтэст бүртгэлтэй, ажил идэвхитэй хайж байгаа ажилгүйчүүдийн тоо 482 хүн бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 108 хүнээр өссөн байна. Нийт ажилгүйчүүдийн 51 хувь буюу 246 хүн нь эмэгтэйчүүд байна. Аймгийн хэмжээнд хөдөлмөрийн насны 10000 хүнд 162 ажилгүйчүүд ногдож байхад Баянжаргалан /533/, Өндөршил /482/, Говь-Угтаал /379/, Гурвансайхан /264/ байгаа нь аймгийн дундачаас дээгүүр байна. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 9.1 хувь нь дипломын болон баклавын дээд, 3.9 хувь нь тусгай мэргэжлийн дунд, 7.7 хувь нь техникийн болон мэргэжлийн, 30.5 хувь нь бүрэн дунд, 32 хувь нь суурь, 14.7 хувь нь бага, 2.1 хувь нь боловсролгүй иргэд байна.

IV. Ажлын байрны зуучлал

Хөдөлмөрийн хэлтсийн 2014 оны эхний 3 сарын мэдээгээр 102 хүн ажлын байранд зуучлагдан орсон байна. Ажлын байранд зуучлагдан ажилд орсон ажиллагчдыг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар авч үзэхэд 31.4 хувь нь үйлчилгээний бусад үйл ажиллагаа, 20.6 хувь нь боловсрол, 17.6 хувь нь боловсруулах аж үйлдвэр, 12.7 хувь нь бөөний ба жижиглэн худалдаа, 17.7 хувь нь бусад салбарт ногдож байна.

V. Нийгмийн даатгал, халамж



Аймгийн нийгмийн даатгалын сангийн орлого 2014 оны эхний 3 сард 4978,6 сая төгрөг, зарлага 4726,7 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеийнхээс орлого 902,3 сая төгрөг буюу 22,1 хувь, зарлага 713,9 сая төгрөг буюу 17,8 хувиар өслөө.

Аймгийн нийгмийн даатгалын хэлтсийн мэдээгээр нийгмийн даатгалд эхний 3 сард 6489 хүн шимтгэл төлөгч, даатгуулагчаар бүртгэгдсэний 1557 хүн буюу 24,0 хувь нь аж ахуйн нэгж, байгууллагаас, 3351 хүн буюу 51,6 хувь нь төсөвт байгууллагаас, 1581 хүн буюу 24,4 хувь нь сайн дураар шимтгэл төлсөн байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад аж ахуйн нэгж, байгууллагын шимтгэл төлөгчид 10,3 хувиар, сайн дурын шимтгэл төлөгчид 73,9 хувиар нэмэгдэж, харин

төсөвт байгууллагын шимтгэл төлөгчид 1,2 хувиар буурсан байна.

Нийгмийн даатгалын сангаас олгосон тэтгэврийн хэмжээ эхний 3 сарын байдлаар 4037,4 сая төг болж, үүний 79,3 хувийг өндөр настны, 14,6 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн, 3,2 хувийг тэжээгчээ алдсаны, 2,9 хувийг цэргийн тэтгэвэр эзэлж байна.


Энэ 2014 оны 3 сард тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэр авагч 6047 хүн байна. Нийт тэтгэвэр авагчдын 77,8 хувь буюу 4704 хүн өндөр насны, 16,7 хувь буюу 1008 хүн тахир дутуугийн, 3,9 хувь буюу 234 хүн тэжээгчээ алдсаны, 1,6 хувь буюу 101 хүн нь цэргийн тэтгэвэр авагчид байна.


Мөн энэ оны 3 сарын байдлаар тэтгэмжийн даатгалын сангаас тэтгэмж авагчид 473, ҮОМШӨ-ний даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж авагчид 31, Ажилгүйдлийн даатгалын сангаас ажилгүйдлийн тэтгэмж авагчид 38 хүн байна.

Эхний 3 сарын байдлаар эрүүл мэндийн даатгалд даатгуулагчийн тоо 11969 байгаагийн 76,5 хувь буюу 9151 төр хариуцах иргэд, 16,0 хувь буюу 1922 малчид, 7,5 хувь буюу 896 оюутан суралцагсад, аж ахуйн нэгжийн эзэн, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн байна.

2014 оны эхний 3 сард нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөө 17,6 хувиар тасарч 1790,8 сая төгрөг болсон байна. Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөгөө Сайнцагаан сумаас бусад сумд бүгд тасалсан байна.

VI. Эрүүл мэнд

 Аймгийн хэмжээнд энэ 2014 оны эхний 3 сард 237 эх амаржиж, амьд төрсөн хүүхдийн тоо 236 болж, өнгөрсөн оны мөн үеэс амаржсан эхийн тоо 18 буюу 8,2 хувиар, хүүхдийн тоо 18 буюу 8,2 хувиар өссөн байна. Энэ оны 3 сард Нийт төрсөн эхчүүдийн 87,8 хувь нь аймгийн нэгдсэн эмнэлэгт төрсөн байна.



Аймгийн хэмжээнд 2014 оны эхний 3 сард нялхсын эндэгдлийн 4 тохиолдол бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеийн түвшинд байгаа ба 1000 амьд төрөлтөнд ногдох нялхсын эндэгдэл 16,9 ноогдож байгаа нь өнгөрсөн оноос буурсан үзүүлэлттэй байна. Харин 1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 1 гарсан нь өнгөрсөн оны мөн үеийн түвшинд байгаа бөгөөд, Өндөршил суманд 1 хүүхэд өвчний улмаас энджээ.




Эрүүл мэндийн газрын мэдээгээр аймгийн хэмжээнд нас баралтын 63 тохиолдол бүртгэгдсэн нь өнгөрсөн оноос буурчээ. Нас барсан хүний 22,2 хувь буюу 14 хүн эмнэлэгт нас барсан байна. Осол гэмтлийн шалтгаант нас баралтын тохиолдол 8 гарч, нийт нас баралтын 12,7 хувийг эзэлж байна. Осол гэмтлийн шалтгаант нас баралтыг бүтцээр нь авч үзвэл амиа хорлосон 1, бусдад хорлогдсон 1, зам тээврийн осол 2, бусад осол 4 байна.

2014 оны эхний 3 сард хорт хавдрын 25 өвчлөлийн тохиолдол шинээр бүртгэгдэж, хорт хавдрын хяналтанд байгаа хүмүүсээс 13 хүн нас барсан байна.

2014 оны эхний 3 сард стационарит шинээр 3097 эмчлүүлэгч хэвтэж, 3055 эмчлүүлэгч эмнэлгээс гарсан бөгөөд нийт 23154 ор хоног ашиглаж, дундаж ор хоног 7,6 байна.

Эхний 3 сард 45009 амбулаторийн үзлэг бүртгэгдсэнээс урьдчилан сэргийлэх үзлэг 28,3%, амбулаторийн үзлэг 54,3 %, идэвхитэй хяналт 12,2 %, гэрийн үзлэг 5,2 %- ийг эзэлж байна.



Аймгийн хэмжээнд энэ оны эхний 3 сард халдварт өвчний 120 тохиолдол бүртгэгдэж, 10000 хүн амд ногдох халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо 27 болж өмнөх оны мөн үеэс өссөн байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нийт халдварт өвчин 18 тохиолдлоор өсч, салхинцэцэг, тэмбүү, гахайн хавдарын өвчлөл 2-3 дахин нэмэгдсэн нь голлон

нөлөөлсөн байна. Мөн Сайнцагаан, Дэрэн суманд ёлом өвчний тус бүр 1 тохиолдол шинээр бүртгэгдлээ.



Халдварт өвчнийг бүтцээр нь авч үзвэл Бэлгийн замын халдвар 40,8 хувь, Амьсгалын замын халдвар 54,2 хувь, сүрьеэ 2,5 хувь, вируст гепатит 0,8 хувь, бусад өвчлөл 1,7 хувийг тус тус эзэлж байна.

VII. Хэрэглээний бараа үйлчилгээний үнэ, үнийн индекс

Хэрэглээний үнийн индекс нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нэг өрхөөр биш, нийт өрхөөр тооцсон үнийн дундаж өөрчлөлтийг харуулна. Тус аймагт 2014 оны 3 сарын байдлаар хэрэглээний үнийн индекс 2013 оны 3 сартай харьцуулахад 12.3 хувиар өсчээ.

Хэрэглээний үнийн индекс 2014 оны 3 дугаар сард 2013 оны 3 дугаар сарынхаас 12.3 хувь өсөхөд хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлэг 12.1 хувь, согтууруулах ундаа, тамхи мансууруулах бодисын бүлэг 19.1 хувь, хувцас бөс, бараа гутлын бүлэг 19.0 хувь, орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлэг 6.4 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлэг 16.5 хувь, тээврийн бүлэг 2.7 хувь, амралт чөлөөт цаг, соёлын бараа үйлчилгээний бүлэг 14.4 хувь, боловсролын бүлэг 13.9 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур, байрны үйлчилгээний бүлэг 21.9 хувиар тус тус нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

2014 оны 3-р сарын 26-ны байдлаар Сайнцагаан сумын хүнсний зах, дэлгүүрт худалдаалагдаж байгаа хүнсний гол нэрийн бараа, бензин, дизель түлш болон ноолуурын үнийг орууллаа.

ХҮНСНИЙ ГОЛ НЭРИЙН БАРААНЫ ҮНЭ, 03 сард, 7 хоногоор

| № | Барааны нэр, төрөл | III/5 | III/12 | III/19 | III/26 |
|----|--------------------------------|-------|--------|--------|--------|
| 1 | Гурил, I зэрэг, кг | 850 | 850 | 850 | 850 |
| 2 | Хонины мах, кг | 7000 | 7500 | 7500 | 7800 |
| 3 | Үхрийн мах, кг | | | | |
| 4 | Ямааны ястай мах | 6500 | 6800 | 6800 | 7000 |
| 5 | Элсэн чихэр, кг | 1500 | 1600 | 1600 | 1650 |
| 6 | Цагаан будаа, кг | 2000 | 2000 | 2000 | 2000 |
| 7 | Шингэн сүү, л | 1800 | 1600 | 1600 | 1600 |
| 8 | Ноолуурын үнэ 1кг: - Цагаан | 55000 | 60000 | 60000 | 85000 |
| | - Бор | 55000 | 60000 | 60000 | 85000 |
| | - Холимог | 55000 | 60000 | 60000 | 85000 |
| 9 | Бензин, А-80, 1 л | 1560 | 1560 | 1570 | 1570 |
| 10 | Бензин, А-92, 1 л | 1810 | 1810 | 1810 | 1810 |
| 11 | Дизелийн түлш, 1 л | 1890 | 1890 | 1890 | 1890 |

VIII. Хөдөө аж ахуй



Аймгийн хэмжээгээр 4 дүгээр сарын 1-ний байдлаар оны эхний төллөх насны хээлтэгч малын 39.4 хувь буюу 322.1 мянган хээлтэгч мал төллөж, гарсан төл 100 хувь буюу 324.0 мянган төл бойжиж байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад төллөсөн хээлтэгч 41.0 хувиар, бойжиж байгаа төлийн тоо 38.9 хувиар өссөн байна.

Аймгийн хэмжээнд энэ оны эхний 3 сарын байдлаар 144 толгой мал хорогдоод байна. Үүний 52.1 хувь нь ямаа, 34.7 хувь нь хонь, 13.2 хувийг бод малын хорогдол эзэлж байна. Нийт хорогдсон том малын 23.6 хувь нь өвчнөөр хорогдсон байна.

IX. Аж үйлдвэр.



Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 2014 оны 3 сарын байдлаар 1127,9 сая төгрөг болж өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 5.3 хувь буюу 56.4 сая төгрөгөөр өссөн байна.

X. Тээвэр Холбоо



Тээврийн салбарын нийт орлого 24,2 сая төгрөг болж өмнөх оны мөн үеэс 37,1 хувиар, зорчигчдын тоо 14,6 мянгад хүрч өмнөх оны мөн үеэс 47,5 хувиар өссөн байна. Нийт зорчигчдын 45,2 хувь нь хот хооронд 54,8 хувь нь орон нутагт зорчсон байна.

XI. Гэмт хэрэг



Цагдаагийн хэлтсийн мэдээгээр 2014 оны 3 сарын байдлаар аймгийн хэмжээнд нийт бүртгэгдсэн гэмт хэргийн тоо 66 болж өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад өссөн байна. Гэмт хэрэгт холбогдогсдын тоо өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 31.1 хувиар өсч 59 хүн холбогдоод байна. 2014 оны 3 сарын байдлаар хүн амь, дээрэм, булаалт, залилангийн гэмт хэрэг гараагүй байна. Өнгөрсөн оны мөн үеэс бусдын өмчийн хулгай 40.0 хувиар өссөний дотор малын хулгай 3.3 дахин өссөн үзүүлэлттэй байна.

Бүртгэгдсэн нийт хэргүүдийг өнгөөр нь авч үзвэл 27.3 хувийг бусдын бие махбодьд гэмтэл учруулсан, 42.4 хувийг хулгайн, 6.0 хувийг тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 3.0 хувийг хүчин, 9.0 хувийг танхайрах хэрэг тус тус эзэлж байна. Нийт гэмт хэргийн 31.8 хувийг согтуугаар үйлдсэн байна. 18 ба түүнээс дээш насны 10000 хүнд ногдох гэмт хэрэг аймгийн дүн 22 хүн байхад Дэлгэрцогт 38, Дэрэн 38, Говь-Угтаал 30, Баянжаргалан 53, Өлзийт, Сайнцагаан, Адаацаг сумд 27 хүн байгаа нь гэмт хэрэг ихтэй сумдад орж байна. Гэмт хэргийн улмаас учирсан хохирол 118.8 сая төгрөг, түүний 57.2 хувь буюу 67.9 сая төгрөгийг нөхөн төлүүлээд байна.

XII. Дундговь аймгийн нутгаар 2014 оны 04 рсард цаг агаар ямар байх тухай урьдчилсан төлөв



Энэ сард агаарын дундаж температур нийт нутгаар 3-8 градус дулаан байх ба олон жилийн дунджаас

1.0-1.5 градусаар дулаан байна. Нэгдүгээр арав хоногийн эхэн болон сүүлч, хоёрдугаар арав хоногийн дунд үеэр бага зэрэг хүйтэрч ихэнх нутгаар шөнөдөө 7-12 градус хүйтэн, өдөртөө 1-6 градус дулаан байна. Харин хоёр ба гуравдугаар арав хоногийн эхний хагаст бүх нутгаар харьцангуй дулаарч шөнөдөө 3-8, өдөртөө 19-24 градус дулаан байна. Бусад хугацаанд ихэнх нутгаар шөнөдөө 3 градус хүйтнээс 2 градус дулаан, өдөртөө 13-18 градус дулаан байна.

Энэ сард орох хур тунадасны хэмжээ нь нутгийн баруун хэсгээр олон жилийн дунджийн орчим, бусад нутгаар олон жилийн дунджаас бага байна. Нэгдүгээр арав хоногийн эхээр нутгийн зүүн хэсгээр, хоёрдугаар арав хоногийн дунд үеэр зарим газраар, гуравдугаар арав хоногийн дунд үеэр нутгийн хойд хэсгээр бага зэргийн хур тунадас орно. Нэгдүгээр арав хоногийн дунд үе, хоёрдугаар арав хоногийн эхэн, гуравдугаар арав хоногийн эцсээр зарим газраар түр зуур 16-18 м/с, хоёр ба гуравдугаар арав хоногийн дунд үеэр зарим үед 24 м/с хүртэл ширүүсч шороон болон цасан шуурга шуурах төлөвтэй.

Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд нөлөөлөх нөлөөлөл

4 дүгээр сарын цаг агаарын урьдчилсан мэдээгээр агаарын дундаж температур нийт нутагт олон жилийн дунджаас дулаан байх ба хур тунадас нутгийн баруун хэсгээр олон жилийн дунджийн орчим, бусад нутгаар дунджаас бага орох төлөвтэй байна. 4 дүгээр сарын ихэнх хугацаанд нийт нутгаар дулаан, хур тунадас багавтар байх төлөвтэй байгаа нь мал аж ахуйд таатай байх хэдий ч сарын дунд үе болон сүүлчээр нутгийн хойд хагаст хур тунадас нойтон цас орж, нутгийн өмнөд хэсгээр хүчтэй салхилж шороон болон цасан шуурга шуурч малын хариулга, маллагаа хүндэрч, нялх төлд таагүй нөлөөлөхөөр байгааг анхаарах хэрэгтэй.

2014 оны 5-р сарын цаг агаарын урьдчилсан мэдээ

Энэ сарын агаарын дундаж температур нь нийт нутгаар 9-14 градус дулаан буюу олон жилийн дунджийн орчим байна. Энэ сард орох хур тунадасны хэмжээ нь нийт нутгаар олон жилийн дунджаас бага орох төлөвтэй.